

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 15 (ТОЙМ)

Хуралдаан 2011 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 14 цаг 30 минутанд эхэлж, 16 цаг 18 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 48 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд даргын албан тушаалд Баасанжавын Ганцэцэгийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд Шарын Отгонхундагыг томилуулахаар дүгнэлт гарган</p>

		нэр дэвшүүлж Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга У.Бямбасүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Эрдэс, баялаг, эрчим хүчний яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд Пүрэвжавын Товуудоржийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Эрдэс, баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Хүрэлбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Зарим иргэдийг төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн жагсаалтаас хасах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх хэсгийг баримталж, 2011 оны “Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай” 50 дугаар тогтоолын 2, 6, 10, 14 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.“Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай” 2011 оны 50 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-аас болон 10 дугаар хавсралтын “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт”-аас</p>

		<p>“Дундговь аймаг, Мэргэжлийн хяналтын газар; Эрүүл мэнд, үйлдвэр, үйлчилгээний хяналтын хэлтэс; Мэргэжилтэн; Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын асуудал хариуцсан; Жадамбын Батчимэг, Баатарын Шинэдаваа” гэсэн хэсгийг, “Дундговь аймаг, Цагаандэлгэр сум; Засаг даргын Тамгын газар; Төрийн сангийн төлөөлөгч; Сумын төрийн сангийн асуудал хариуцсан; Сэрээтэрийн Отгонхорлоо” гэсэн хэсгийг, “Дундговь аймаг, Өндөршил сум; Засаг даргын Тамгын газар; Мэргэжилтэн; Нийгмийн бодлогын асуудал хариуцсан; Пүрэвийн Азжаргал” гэсэн хэсгийг, “Дундговь аймаг, Луус сум; Засаг даргын Тамгын газар; Мэргэжилтэн; Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан; Бямбаагийн Баттулга” гэсэн хэсгийг тус тус хасах,</p> <p>2.“Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай” 2011 оны 50 дугаар тогтоолын нэгдүгээр зүйлд заасан нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан Жамъянлхамын Саранчимэгийг аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын "Төрийн сангийн төлөөлөгч"-ийн, Таяагийн Мөнхсүрэнг аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын "Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн"-ий албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байсан П.Бат-Өлзийгөөс Дорнод аймгийн Засаг даргын 2011 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн Б/02 дугаар захирамжийг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлд гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Энэ асуудлыг дараачийн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулав.</p>